



**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Ө.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ОТГОНБАЯР

2024-05-30

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

“Алсын хараа”

Дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ

Дэлхийн түвшинтэй хөл нийлүүлнэ

“Эрхэм зорилго”

Төрийн бүртгэлийг төгөлдөршүүлж

Улсын бүртгэлийг ухаалагжуулж

Цаасан бүртгэлийг цахимжуулж

Иргэдэд ээлтэй байгууллага байна

“Уриа”

Эхээс мэндэлж нэрээ авахаас

Эх дэлхийдээ шингэн үдүүлэх

Уудам орон зүйд бид үйлчлэнэ

Улсын бүртгэл тантай хамт

“Чанарын бодлого”

Хууль тогтоомжийг чухалчилж

Хүний эрхийг дээдэлж

Үйл ажиллагаагаа сайжруулж


Үйлдэл бүхнээ хянаж

Чадвар ёс зүйгээр манлайлж

Чадамж гүйцэтгэлээр тэргүүлж

Түмэн хэрэглэгчийг хамруулсан

Төрийн санах ой байна.



1. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

2024 оны эхний хагас жилд тус хэлтэс нь төрийн захиргааны албан хаагч 18, төрийн үйлчилгээний албан хаагч 5, байнгын гэрээт албан хаагч 2, түр гэрээт албан хаагч 4 нийт 29 албан хаагчтайгаар УБЕГ-ын даргын тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна.



1.1. Албан хаагчдын сургалтын талаар

Хүний нөөцийн системийн сургалтуудад тухай бүр хамрагдан үнэлгээ, сорил шалгалтуудыг өгч ажиллалаа.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Төрийн албаны зөвлөл болон хэлтсийн дотоод нөөц бололцоогоо ашиглан зохион байгуулагдсан сургалт:

- Нийт албан хаагчдад зориулсан- 29
- Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой- 2

- Иргэний улсын бүртгэлтэй холбоотой- 2
- Архивч, бичиг хэрэг, нягтлангийн – 2
- Удирдах албан тушаалтны- 2
- Монгол Улсын Их хурлын Сонгуультай холбоотой -4
- Төрийн албаны зөвлөл-10
- Бусад сургалт -7

Мөн дотоодод хийсэн сургалтын хүрээнд:

Ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн нийт албан хаагчдад сургалт орсон.



ISO:9001-2015-ын Аудит, шалгалтийг хэрхэн хийх талаар стандартын аудитор, Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн хэлтсийн нийт хамт олонд сургалт орсон.




Улсын ахлах бүртгэгч Ө.Ганзориг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нэмэлт өөрчлөлтийн талаар 2 удаагийн сургалтыг хэлтсийн хамт олонд орсон.



Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулиар Улсын бүртгэгч Н.Алтанцэцэг хэлтсийн нийт хамт олонд сургалт орсон.



“Хүүхдийн сэтгэл зүйн гэмтэл, шинж тэмдэг, даван туулах арга зам” сэдэвт сургалтыг сэтгэл зүйч Н.Хулан урьж хэлтсийн хамт олонд сургалт оруулсан.



ТАЗ-ийн 7:4:10 сургалт болон төрийн бусад байгууллагаас зохион байгуулагдаж буй сургалтуудыг хэлтсийн албан хаагчдад цаг тухай бүрд хүргэн сургалтанд хамруулан ажилласан.

2. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны эхний хагас жилийн байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр нийт 10440 бүртгэл хийгдсэн.


Үүнд: газраас бусад үл хөдлөх эд хөрөнгий бүртгэл 7129

газрын бүртгэл 3344


бүртгэл хийхээс 151 мэдүүлэг татгалзсан болно.



Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг графикаар:



3. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1. Тоон гарын үсэг олголтын талаар

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 01 ний өдрөөс иргэдэд тоон гарын үсэг олгож эхэлсэн.

2024 оны 01 дугаар сарын 02-наас 5 дугаар сарын 30 ны хугацаанд Аймгийн хэмжээнд олговол зохих 73598 иргэнээс хагас жилийн байдлаар 29055 тоон гарын үсэг буюу 39,5 хувьд нь олгоод байна.

2024 оны 01 сарын 01нээс 2024 оны 05 сарын 30 хүртэлх

Огноо	Нийт	Иргэний үнэмлэх	Мобайл апп	Эрэгтэй	Эмэгтэй	0 – 24 хүртэлх	25 – 44 нас	45 – 60 нас	60 – с дээш
2022 он	14686	11637	3049	7353	7333	684	8149	5227	626
2023 он	9935	4054	5881	4586	5349	998	5355	2975	607
2024 он	3804	297	3507	1806	1998	494	1867	1096	354
Нийт	28425	15988	12437	13745	14680	2176	15371	9298	1587

3.2. Иргэний үнэмлэх олголтын талаар

Тайлангийн хугацаанд нийт 2667 иргэнд иргэний үнэмлэх олголоо. Нийт иргэний үнэмлэхний 883 нь 16 нас хүрч анх удаа иргэний үнэмлэх авч буй иргэд байна. Мөн иргэний үнэмлэхний хугацаа дууссан иргэдийн 25 насны сунгалт 510, 45 насны сунгалт 617, хаяж үрэгдүүлсэн болон бусад шалтгаанаар 647 иргэний үнэмлэх олгож ажиллалаа.

№	Үзүүлэлт	Тоо	
1	16 нас хүрч шинээр олгогдсон үнэмлэх	883	
2	Дахин олгосон үнэмлэх	647	
3	Гадаадад	20	
4	Хугацаа дуусч солиулсан	25 нас хүрч	510
		45 нас хүрч	617
	Нийт	2677	

3.3. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаар

Тайлангийн хугацаанд иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр нийт 1381 бүртгэл хийгдсэнээс 724 төрөлт, 205 гэрлэлт, 89 гэрлэлт дуусгавар болсон, 17 хүүхэд үрчлэлт, 50 овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл, 43 эцэг тогтоосны бүртгэл, 261 нас барсны бүртгэл хийн сар бүрийн мэдээ, тайлан, ИУБ маягтуудыг УБЕГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллаа.

ИГББ-н 8 төрлийн бүртгэлийн 30127 хуудас материалыг бүрэн цахимжууллаа.



3.4. Үндэсний энгийн гадаад паспорт олголтын талаар

Хагас жилийн байдлаар 4951 иргэнд гадаад паспорт олгосноос 4188 иргэнд цахим гадаад паспорт, 763 иргэнд энгийн цахим паспорт олголоо.

3.5. Иргэн шилжин суурьших хөдөлгөөний талаар

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын дагуу 2024 оны бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэл.

2024 оны 05 сарын 30 ны байдлаар

№	Насанд хүрсэн иргэн	16 хүртэлх насны хүүхэд	Нийт
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн			
1	1164	546	1710
Сум, баг хооронд шилжин ирсэн			
2	3703	2431	6134
Нийт			
	4867	2977	7844

4.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны эхний хагас жилийн байдлаар хуулийн этгээдийн чиглэлээр нийт 626 бүртгэл хийсэн. Үүнд:

Шинээр байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани 143, төрийн бус байгууллага 17, үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1, хоршоо 27, Нөхөрлөл 1, Төрийн байгууллага 2, Боловсрол сургалтын байгууллага 1, улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон.

Мөн 362 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд нь холбогдох бичилтийг хийж баталгаажуулсан.

Улсын бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн, солих хүсэлт гаргасан 67 хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авч хянан улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон.


Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу 8 хуулийн этгээд татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгэж, хасалт хийсэн.

Мөн E-business.mn портал сайтаар хуулийн этгээдийн 638 үйлчилгээ үзүүлж бүртгэл хийсэн.

Иргэн, хуулийн этгээд тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих журмын хэрэгжилтийн хүрээнд 258 хуулийн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх хяналтын хуудас олгож, 48 хуулийн этгээд тамга, тэмдэг хураан авсан.

Улсын бүртгэлд салбар төлөөлөгчийн 8 бүртгэл шилжин ирсэн хуулийн этгээдийн 11 бүртгэл хориг тавьсан 1, эрх сэргээсэн 5 бүртгэл тус тус хийсэн.

Графикаар харуулбал:



5. АЛБАН БИЧГИЙН ЭРГЭЛТ, ТУШААЛ, ШИЙДВЭР, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЛААР

Албан бичгийн эргэлтийн талаар

Тайлангийн хугацаанд тус хэлтэст нийт 812 албан бичиг ирснээс 566 хариутай бичиг. Тухайн хариутай бичгийг цаг хугацаанд хариуг хүргүүлж ажилласан.

Ирсэн бичгүүдийг ангилан авч үзвэл.

Цагдаагийн байгууллагаас 107 албан бичиг хүлээн авч албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 160 албан бичиг хүлээн авч албан бичгээр болон архивын лавлагаагаар хариу хүргүүлсэн.

Шүүхийн байгууллагаас 103 албан бичиг хүлээн авч хариу хүргэсэн.

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар болон харьяа байгууллагаас 41 бичиг хүлээн авч хариу хүргэсэн.

УБЕГ-аас 151 албан бичиг ирснийг ангилан авч үзвэл тушаал 8, үүрэг даалгавар, чиглэл 40 тус тус ирсэн байна.

Бусад байгууллагаас 250 албан бичиг хүлээн авч хариуг хүргүүлэн ажилласан байна.

5.2. Тушаал шийдвэр, хурлын тэмдэглэлийн талаар

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А тушаал 12, Б тушаал 4 гарч даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл 4, хамт олны хурлын тэмдэглэл 1, хэлтсийн шуурхайн тэмдэглэл 20 хөтлөгдсөн байна.

5.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн талаар

Тайлангийн хугацаанд иргэдээс нийт 19 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Мөн тайлант хугацаанд албан хаагчдаас 15 хүсэлт ирснийг хүлээн авч 1 хүсэлтийг бүрэн шийдвэрлэж 14 хүсэлт шийдвэрлэх хугацаандаа явж байна.

Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг ангилан авч үзвэл:

1. Өргөдөл, гомдлын ангилал				
Өргөдөл	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал
	9		-	-
2. Өргөдөл, гомдол хүлээн авсан хэлбэр				
Бичгээр		Утсаар		ЗГ 1111
15		4		-

3. Өргөдөл гомдлын агуулга			
Иргэний бүртгэлийн чиглэлээр	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр	Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр	Бусад /Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт/
0	4	0	15

6. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

Хэлтсийн 2024 оны эхний хагас жилийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11267, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 626, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 10381, архивын чиглэлээр 13059 бүртгэл, нийт 35333 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж, сар бүр тоон мэдээг Хяналт, шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Үүнд:



2024 оны эхний хагас жилд 6949 бүртгэлийг шалган 11 зөрчил илрүүлснээс зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан.

Иргэн, хуулийн этгээдээс иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчилтэй холбоотой нийт 47 өргөдөл, гомдлыг хүлээн авснаас иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 18, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 29 гомдлыг хуульд заасан журмын дагуу хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үйлдэн, зөрчлийг

бүрэн арилгаж шийдвэрлэж, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан.



2024 оны эхний хагас жилийн байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 117 иргэн, 2 хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хүлээн 4285000 төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэн хуулийн хугацаанд прокурорт хянуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн иргэний улсын бүртгэлийн цахимжуулах ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт 10754 бүртгэл 30127 хуудас цахимжуулалтад хяналт тавьж ажилласан.

Дээрх цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн мэдээлэл бүрэн, бичилтийн шаардлагыг хангасан, эх хувьтай таарч байх бөгөөд иргэний улсын бүртгэлийн маягтад бичигдсэн мэдээлэл бичилтийн шаардлага хангасан, нотлох баримтын бүрдлийн шаардлага хангасан алдаа, зөрчилгүй байна.

Тайлант хугацаанд 10440 эд хөрөнгийн эрхийн бүртгэл бүртгэгдсэн байх бөгөөд тус бүртгэлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн гүйцэд цахимжсан эсэхийг түүвэрчлэн шалгахад өмчлөх эрхийн гэрчилгээний хуулбарыг цахимжуулаагүй 5 зөрчил илэрсэн.

Мөн хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр бүртгэгдсэн 10754 бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд тухайн бүртгэлийн нотлох баримт бүрэн гүйцэд цахимжиж бүртгэсэн эсэхийг түүвэрчлэн шалгахад гэрлэсний, гэрлэлт цуцласны, нас барсны зэрэг 6 бүртгэлийн эх нотлох баримтыг улсын бүртгэгч цахимжуулсан байх боловч цахимжуулалт харагдахгүй зөрчил илэрсэн.

Мөн дээрх хугацаанд хуулийн этгээдийн 626 бүртгэл бүртгэгдсэн байх бөгөөд тус бүртгэлүүд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн цахимжсан зөрчил илрээгүй болно.

Хяналт шалгалтанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийг таниулах, энэ төрлийн зөрчлийг давтан гаргуулахгүй, урьдчилан сэргийлэх зорилгоор гарын авлага, санамжийг бэлтгэн 5 хуулийн этгээдэд тараан өгч, Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж, Зөрчлийн тухай хуулийг сурталчлах арга хэмжээг авч ажилласан.

7. САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

7.1 Батлагдсан төсвийн хүрээнд хэлтсийн мөнгөн хөрөнгө үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулна.

Эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн 3 арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд дээрх арга хэмжээг санхүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 334,1 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн 54,03 сая төгрөг, нийт 646,45 сая төгрөгийн төсвийн зарцуулалтын эрх нээгдсэн. Батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээ, зардлын бүлэг зүйлийн дагуу хугацаанд нь зарцуулан ажиллаж байна.

Батлагдсан төсөв, зарцуулалт / арга хэмжээ тус бүрээр /төгрөгөөр/

№	Арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Хэтрэлт /хэмнэлт/
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	334,160,500	278,389,155	55,771,344.66
2	Буслах үйл ажиллагааны зардал	54,032,450	49,314,009	4,718,440.77
3	Ажил олшлшчоос тэтгэмж	200,000	200,000	-
-	Нийт дүн	388,392,950	214,767,622	12,242,478

1. Үйлчилгээний орлого төвлөрүүлэлт

Тус хэлтэс нь 2024 онд 320.0 сая.төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээс 2024 оны 04 дугаар сарын 30-ны байдлаар 152,4 сая төгрөгийг сар бүр хугацаанд нь төвлөрүүлсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 47,6 хувьтай байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлт / 2017 – 2024 он /

сая төгрөгөөр

№	Тайлант он	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлт /Хувь/
1	2017.12 сар	320	345.7	108.03%
2	2018.12 сар	320	367.7	114.91%
3	2019.12 сар	320	331.4	103.56%
4	2020.12 сар	320	280.5	87.66%
5	2021.12 сар	320	359.19	112.25%
6	2022.12 сар	320	334.1	104.41%
7	2023.05 сар	320	347.1	108.47%
8	2024.04 сар	320	152.4	47.60%

7.2 Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамт хуульд заасан хугацаанд ерөнхий газарт хүргүүлнэ.

УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст дараах нэр төрлийн мэдээ, тайланг “Төсвийн тухай хууль”-д заасан хугацаанд нь сар, улирал бүр цахим шуудангаар болон шаардлагатай тохиолдолд эх хувиар нь хүргүүлэн ажиллаж байна.

Тайлант онд Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас орон даяар явагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого”-д хуулийн хугацаанд бүрэн хамрагдан Өмч эзэмшүүлэх гэрээг **“96 хувь буюу Сайн”** дүгнүүлсэн болно. Мөн түүнчлэн ашиглалтын хугацаа дууссан элэгдэлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг актлуулах саналыг тухай бүр СААХ-н хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

7.3 Хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, зөрчил бага илэрсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байна

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2024 оны 02 дүгээр сарын 1-ны

өдөр Орхон аймаг дахь Төрийн Аудитын газарт хүргүүлсэн бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдөр “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” санал дүгнэлт авсан болно.

2022 оны Санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 05 дугаар сарын 29-ны өдөр гарган Аймаг дахь Төрийн Аудитын болон УБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газруудад тус тус хүргүүлсэн болно.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.28 № 17

танай _____ -ны № _____ -т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
М.ОТГОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант онд улсын төсвөөс 638,833.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 102,537.3 мянган төгрөг нийт 741,370.6 мянган төгрөгийг зардлын зүйл ангиар зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 107,440.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А-1/1279 дүгээр хөрөнгө шилжүүлэх зөвшөөрлийн дагуу 19,844.0 мянган төгрөгийн архивын шүүгээг шилжүүлжээ. Дээрх онцгойлсон асуудалтай холбоотой аудиторын дүгнэлт өөрчлөгдөөгүй болно.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолоор Улсын бүртгэлийн хэлтсийн орон нутгийн

D:\my doc \alban bichig\2024-A4.doc

2024 онд тус хэлтэс нь орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж Засаг даргын нөөц сангаас 4 гэрээт ажилтны цалин болох 11.6 сая төгрөгийн санхүүжилт, Мөн хөдөө орон нутгийн нэмэгдэл цалин 42,4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

8. ЗОХИОН БАЙГУУЛСАН ШИНЭЛЭГ АЖИЛ



Аймгийн Засаг даргын тамгын газрын иргэдэд үйлчилэх Цахим төвд 24/7 цахим үйлчилгээний Дөт машин байршуулан 5803 иргэнд, хэлтсийн үйлчилгээний танхимд нэг Дөт машин байршуулан 582 иргэнд тус тус цаг хугацаа орон зай харгалзахгүйгээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-г угтан хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгууллаа.



"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг угтан Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Сархиа уулын энгэрт 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 23 ширхэг агч моднуудыг тарьж цэнэг усалгаа арчилгааг хийж ажиллалаа.






Байгууллагын Эцэг, эхийн зөвлөлөөс санаачлан албан хаагчид зориулсан зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

Тус хэлтсээс Хууль хяналтын байгууллагуудын дунд “Волейбол”-ын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж тус хэлтсийн баг





“Дөтгөөр” байр эзэллээ.


Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Бүртгэлийн тухай хууль, журам, Цахим бүртгэлийн тухай иргэд аж ахуй байгууллагуудад орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сайтуудаар 11 удаа, хэвлэлийн бага хурлыг нэг удаа тус тус зохион байгуулж иргэд олон нийтэд сурталчилан ажиллалаа.




Орхон аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2024.05.01-ны өдөр Зэст багийн нэгдсэн байр “Хууль зүйн туслалцааны төвд” жил бүр зохион байгуулагддаг Хуульчдийн “Про боно” өдөрлөгт 3 бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ, мэдээ, мэдээлэл, зөвөлгөөг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад өгч ажиллалаа.



Тус хэлтсээс 3 бүртгэлийн чиглэлээр 3 контент хийж иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.



2024 оны 04 сарын 04-ны өдөр тус хэлтэс нь “Хотын их цэвэрлэгээ”-нд нэгдэж “Найрамдал” өндөрлөг орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэлээ.



2024 оны 03 сарын 28-ны өдөр Гамшгийн үеийн зарлан мэдээллэх дохиогоор хэлтсийн хамт олон идэвхитэй оролцлоо.




2024 оны эхний хагаст Төрийн албаны ерөнхий шалгалт 2 удаа зарлагдаж тус хэлтсийн Улсын бүртгэгч М.Жавзансүрэн, Мэдээлэл технологийн ажилтан Б.Лхамцэрэн нар шалгалтад орсон иргэдийн бүртгэн хамруулж ажиллалаа.

Монгол Улсын төрийн албаны ерөнхий шалгалт өнөөдөр /2024.03.13/ 08:30 минутад улс орон даяар нэгэн зэрэг эхэлж хэвийн үргэлжилж байна. Энэ удаагийн ерөнхий шалгалтад Орхон аймагт нийт 101 иргэн бүртгүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 03 дугаар сарын 13, 14-ны өдрүүдэд 7 ээлжээр тогтоосон цагуудад шалгалтыг авах юм. Ерөнхий шалгалтыг Улсын бүртгэлийн хэлтсээс хурууны хээгээр шалгалтад орох иргэдийг бүр... See more



Тус хэлтсээс Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн талаар мэдээ мэдээллийг ХЭЗХ-ын Хуулийн цаг нэвтрүүлэгээр иргэд олон нийтэд сурталчилан ажиллалаа.



Тус хэлтсийн хамт олон “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяны хүрээнд өдөр бүр дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн ба даралтны аппаратаар хэмжилт хийж тэмдэглэл хөтөлж хэвшсэн.



ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН

2024.05.30

Орхон аймаг

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүрт шинэчлэх;</p>	<p>Байгууллагын зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг http://www.orkhon.burtgel.gov.mn цахим хуудас 42, https://www.facebook.com/orkhonburtgel фэйсбүүк хуудас 131 мэдээ мэдээлэл болон мэдээллийн самбартаа иргэдэд бүртгэлийн талаарх мэдээллийг ил тод ойлгомжтой байдлаар байршуулсан.</p> <p>Байгууллагын цахим хуудасны нүүр хэсэгт /www.orkhon.burtgel.gov.mn-д/ бүртгэлийн болон төрийн цахим үйлчилгээний сайтуудыг байршуулсан</p> <ul style="list-style-type: none"> • Хууль зүйн дотоод хэргийн яамны https://mojha.gov.mn/, • Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын сайт https://erdenet.mn/medee/, • 2024 оны МУИХ сонгуулийн сонгогчийн мэдээлэлтэй танилцах сайт https://election.burtgel.gov.mn/ • Авлигатай тэмцэх газрын сайт http://iaac.mn/ • Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем. https://e-mongolia.mn/home • Улсын бүртгэлийн лавлагаа, үйлчилгээний цахим систем http://burtgel.gov.mn/service/index.php • Улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийн http://opendata.burtgel.gov.mn/ • Хуулийн этгээдийн оноосон нэр авах https://e-business.mn/home <p style="text-align: right;">/Зураг 1/</p>	100 %
2.	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр албан тушаал, ажиллах журам, харилцах</p>	<p>Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, утасны дугаар, өрөөний байршил зэргийг харуулсан мэдээлэлийг байгууллагын www.orkhon.burtgel.gov.mn цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулсан.</p>	100 %

	утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүрт шинэчлэх;	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн ил тод байдал шийдвэрлэлтийн мэдээ, тайланг улирлаар гарган иргэдэд нээлттэй хүргэхийн зэрэгцээ аймгийн ЗДТГ болон УБЕГ-т тогтмол хүргүүлэн ажиллаж байна. 7 хоног бүрийн Лхагва гаригт иргэдийг сонсох цаг гаргаж санал хүсэлтийг биеэр, цахимаар сошиалаар, 70358989 утас болон үйлчилгээний зааланд саналын хайрцаг байршуулан авлаа. <i>/Зураг 2/</i>	
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус хэлтсээс иргэдэд үзүүлдэг иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ авахад шаардагдах бүрдүүлбэрийн жагсаалт, өргөдлийн загвар болон үнийн мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, мөн бүртгэгч нарын урд QR кодоор авах боломжийг ханган мэдээллийг ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. <i>/Зураг 3/</i>	100 %
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус хэлтэс нь мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 3 бүртгэлийн мэдээлэл, брошюрын самбарыг байршуулан ажиллуулж байна. Тус самбарт хэлтсийн танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын болон хэлтсийн даргын тушаал шийдвэр, захиргааны байгууллагын шийдвэр, сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, 3 бүртгэлийн үйлчилгээний талаар иргэдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч цаг тухай бүрд мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. <i>/Зураг 4/</i>	100 %
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн	<ul style="list-style-type: none"> • Хууль зүйн дотоод хэргийн яамны https://mojha.gov.mn/, • Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын сайт https://erdenet.mn/medee/, сайтуудыг байгууллагын цахим хуудас болох www.orkhon.burtgel.gov.mn-д холбосноор иргэдийг хуулийн төсөлд саналаа өгөх нөхцөл боломжоор бүрэн хангасан. <i>/Зураг 5/</i>	100 %

	саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;		
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	<p>Иргэдэд цахим үйлчилгээг сурталчилж чадсаны үр дүнд www.e-mongolia.mn портал сайт болон аппликейшнээр үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэн ажиллаж байна.</p> <p>638 хуулийн этгээдийн оноосон нэрийн хүсэлтийг www.les.e-business.mn -ээр хүлээн авч баталгаажуулсан.</p> <p>Цахимаар тус хэлтэст хандаж хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийлгэх 638 хүсэлт, иргэний шилжилт хөдөлгөөний 5 хүсэлт ирсэнийг цаг хугацаанд нь баталгаажуулан бүрдүүлбэр дутуу бүртгэлийг хүлээн авахаас татгалзаж хариуг өгсөн.</p> <p>Цахим гадаад паспортын зургийг https://photo.burtgel.gov.mn/ сайтаар хүлээн авахаас гадна хэлтсийн байранд зураг авч үйлчилж байна.</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2 ширхэг "Дөт" киоск 24/7 цахим машиныг Аймгийн "Цахим төв"-д болон хэлтсийн байранд тус тус байршуулан үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>2024.01.01-2024.05.29-ны өдрийн байдлаар лавлагаа 5411, тоон гарын үсэг 392 үзүүлсэн байна.</p> <p>Төлбөрийн Гэрэгэ киоск болон пос машинаар 2024.01.01-2024.05.29-ны хооронд давхардсан тоогоор нийт 9452 удаа бүртгэлийн үйлчилгээний төлбөр төлөгдсөн байна. Иргэдэд үйлчилгээг шуурхай хүргэх, буцаахгүй байх зорилго тавьж иргэдээс ямар шалтгаанаар буцаадаг тухай санал асуулга авч гарын авлага, мэдээллийг угтах үйлчилгээний ажилтан хариуцан өгдөг болсон.</p> <p style="text-align: right;">/Зураг 6/</p>	100 %
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа	Хамааралгүй заалт	-

	тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;		
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хамааралгүй заалт	-
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хамааралгүй заалт	-
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Байгууллагын албан хаагчийн дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Сул орон тоо гарах ажлын байрны зарыг өөрийн цахим хуудас, фэйсбүүк хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ажлын байрны зар хэсэгт оруулж зарыг явуулж байна. <i>/Зураг 7/</i>	100 %
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн	100 %

	байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	дүрэм"-ийг мөрдөн, цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн ил тод байршуулан ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг "7:4:10" сургалтад 7 хоног бүр нийт албан хаагчдыг бүртгэн хамруулж байна. <i>/Зураг 8 /</i>	
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын цахим хуудсанд хэлтсийн даргын тушаалууд, байгууллагын бүтэц, хүний нөөц, албан хаагчдын албан тушаал, холбоо барих утас зэрэг мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. <i>/Зураг 9/</i>	100 %
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	2024 онд гарсан хүний нөөцийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг мэдээллийн самбар болон нээлттэй ажлын байрны зарыг www.orkhon.burtgel.gov.mn цахим хуудасны ил тод цэсэнд болон www.facebook.com/orkhonburtgel фэйсбүүк хуудаст байршуулсан. <i>/Зураг 10/</i>	100 %
5.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг нийт албан хаагчдад сурталчлан таниулж, байгууллагын цахим хуудсанд мэдээлж, албан хаагчдын 2024 оны улирлын тайлан болон хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг тус журмын дагуу үнэлэн даргын зөвлөлөөр албан хаагч тус бүрээр хэлэлцхээр төлөвлөн ажиллаж байна.	100 %
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хэрэгжилтийн дундаж хувь:			

---oOo---

ХАВСРАЛТ
Зураг1

Алсын харгаа

- Дэлхийн үндэстний хамтын ажиллагаа
- Дэлхийн нийгмийн хөгжлийн зорилго

Эрхэм зорилго

- Төрийн байгууллын гажуудсан үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ

Үнэт зүйл

- Өмчийн хөрөнгийн хөгжлийн зорилго
- Өмчийн хөрөнгийн хөгжлийн зорилго
- Өмчийн хөрөнгийн хөгжлийн зорилго
- Өмчийн хөрөнгийн хөгжлийн зорилго
- Өмчийн хөрөнгийн хөгжлийн зорилго

Чанарын бодлого


- Төрийн байгууллын үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ
- Төрийн байгууллын үйлчилгээ

Стратегийн зорилт


- Стратегийн зорилт
- Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ

Тэргүүлэх чиглэл


- Тэргүүлэх чиглэл
- Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ
 - Төрийн байгууллын үйлчилгээ




Зураг 4




Зураг 5




Зураг 6





Зураг 7



Зураг 8



Зураг 9





Д/д	НЭГ	АЛБАН ТУШАЛТ	УТАС	И-МЭЙЛ ХААНГ
1	МОНГОЛЫН	Төрийн дарга	7033-8122	m.mongol@tse.gov.mn
2	СЭНГИЙН	Улаанбаатар Улаан Засаг захиргаа	7033-8164	uul@tse.gov.mn
3	ӨГӨМӨН	НҮӨТ-ийн дарга Бонд Уриан-Орхон	9310-7242	u.orian@tse.gov.mn
4	С.Жабыралин	ЭХЭҮБ-ийн төлөөлөгч дарга, улсын дарга	-	-
5	Э.Сүхбаатар	ЭХЭҮБ-ийн төлөөлөгч ТӨБ өргөө, улсын дарга	7033-8989	e.sukhbaatar@tse.gov.mn
6	М.Цогтбаяр	Хүнийн ажиллагаа Улаан Засаг захиргаа	7033-8925	m.cogtбаяр@tse.gov.mn
7	Н.Амгаланцэр	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8189	n.amgalantser@tse.gov.mn
8	Г.Цэцэгэл	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8989	g.tsetsegel@tse.gov.mn
9	Т.Мөнх-Оюун	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8989	t.munkhoyun@tse.gov.mn
10	Н.Ташвандал	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	9959-4184	n.tashvandal@tse.gov.mn
11	Б.Мөнхтүвшин	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8989	b.munkhtushin@tse.gov.mn
12	С.Сүхбаатар	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8989	s.sukhbaatar@tse.gov.mn
13	М.Жавхандорж	Иргэний бүтцийн Улаан Засаг захиргаа	7033-8989	m.javkhandorj@tse.gov.mn
14	Г.Мөнхтүвшин	Жагсааны өргөө Улаан Засаг захиргаа	9933-4203	g.munkhtushin@tse.gov.mn
15	С.Оюунцэцэг	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	s.ojuuncetseg@tse.gov.mn
16	О.Сэлэнгэ	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	o.selenge@tse.gov.mn
17	Д.Баянцэцэг	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	d.bayantsetseg@tse.gov.mn
18	Б.Бат-Эрэнэ	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	b.bat-eren@tse.gov.mn
19	М.Давхандорж	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	m.davkhandorj@tse.gov.mn
20	Ш.Сэлэнгэ	Баталгааны өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	sh.selenge@tse.gov.mn
21	Б.Лхамсүх	Мэдээлэл технологийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	b.lhamasukh@tse.gov.mn
22	Т.Оюун	Бичиг хариулах өргөө Улаан Засаг захиргаа	7033-8975	t.ojuun@tse.gov.mn
23	Д.Амгаланцэр	За нэрэмчийн өргөө Улаан Засаг захиргаа	7033-8989	d.amgalantser@tse.gov.mn
24	Б.Сэнгэр	Иргэний үйлчилгээ Улаан Засаг захиргаа	-	b.senger@tse.gov.mn
25	Аян-Ирээдийн	Хэлтэс	-	ayan-ireediin@tse.gov.mn
26	Савдран	Хэлтэс	-	savdran@tse.gov.mn

ШИШЭ МЭДЭЭ

- Монголын засгийн газрын үйлчилгээний төв
- Төрийн үйлчилгээний төв
- Улаанбаатар Улаан Засаг захиргаа
- Өгөгмөн НҮӨТ-ийн дарга
- С.Жабыралин
- Э.Сүхбаатар
- М.Цогтбаяр
- Н.Амгаланцэр
- Г.Цэцэгэл
- Т.Мөнх-Оюун
- Н.Ташвандал
- Б.Мөнхтүвшин
- С.Сүхбаатар
- М.Жавхандорж
- Г.Мөнхтүвшин
- С.Оюунцэцэг
- О.Сэлэнгэ
- Д.Баянцэцэг
- Б.Бат-Эрэнэ
- М.Давхандорж
- Ш.Сэлэнгэ
- Б.Лхамсүх
- Т.Оюун
- Д.Амгаланцэр
- Б.Сэнгэр
- Савдран

shilandang.gov.mn/7553

Төрийн Ерөнхийлөгч Засгийн Газар

ОРОН АЙМ УРСЫН БҮТЭГЭЙН ХЭЛТЭС

Төрийн Ерөнхийлөгч Засгийн Газар Бүтцийн Ерөнхий Газар Дарга
 Үүсгэн байгуулагдсан өдөр: 2024/07/27
 Дарга: Микхалдорж Отгонбаяр
 Утас: 99553238
 Нийтлэн байршил: Шатдагчид Одоогой Утас: 99558217

№	ШИШЭН ДАНСЫН ХЭМЖЭЭЛИЙН ТӨВЧӨЛ	ХӨРӨНГӨ ОРГУУЛАЛТ, ТЕНДЭР, ХОУДААН АВАЛТ												БУСАД		
		2022 1-р сар	2022 2-р сар	2022 3-р сар	2022 4-р сар	2022 5-р сар	2022 6-р сар	2022 7-р сар	2022 8-р сар	2022 9-р сар	2022 10-р сар	2022 11-р сар	2022 12-р сар	2022 4-р сар	2022 5-р сар	
1	Дараа жилийн төслийн төсөл (Бүтэц жижгэр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Төслийн байгуулалтын бэлтгэлд төсөл, гүйцэтгэл, хяналт хяналтын шалтгаан тайлбарын хяналт (Бүтэц жижгэр, Хагас жижгэр, Умарал дур, Сар дур)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Түрхэйн жилийн төсөвт орсон консалт өөрчлөлт (Хуай дур)	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
4	Өнөөх сая төслийн зарчлын хяналт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урчуулууд, зарцуулсан тайлан (Бүтэц жижгэр, Хагас жижгэр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хандив, тусламжийн хэмжээ, түрний зарцуулалтын тайлан (Бүтэц жижгэр, Хагас жижгэр)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Зураг 10

ОРОН АЙМ УРСЫН БҮТЭГЭЙН ХЭЛТЭС

ШИШЭН ДАНС

САНХҮҮГИЙН ИЛ ТУД БАЙДАЛ
 ХУРАЛ, СУРГАЛТ, СЭМИНАР, ХӨРӨНГӨЛӨГЧИЙН ЗАР
 ЖИЛ, УЛМАРАЛЫН ТАЙЛАН
 ЖИЛ, УЛМАРАЛЫН ӨС ЗӨЙН ДҮГИЙН
 ХӨРӨНГӨЛӨГЧИЙН ДӨТТӨГӨЛ
 ХӨРӨНГӨЛӨГЧИЙН ИЛ ТУД БАЙДАЛ

ВИДЕО МЭДЭЭ

Урьдчилсан 2022 оны төсөв

Урьдчилсан 2022 оны төсөв

Урьдчилсан 2022 оны төсөв

Урьдчилсан 2022 оны төсөв

Урьдчилсан 2022 оны төсөв

ОРОН АЙМГИЙН ТУХАЙ

Эрүүс нэвчлэл бүтэцтэй байгуулалт Эрдэнэт нь "Эрдэнэтний өвөр" нь өдөр сайн төгсгөл 1972 онд эхэлж төхөөрөмж, 1974 оныг бүтэцтэй байгуулалт Эрдэнэт орон нутагийн өмч хөрөнгөний өмчлөлийг үндэс болгон байгуулагдсан. Үндэс төхөөрөмж нь өдөр сайн төгсгөл 1978 онд Эрдэнэт орон болон байгуулагдсан.

АЙМГИЙН ТҮҮХ БОЛОН ДУРСГАЛТ ГАЗАР

Нийслэлд ирээдүйн 1995 онд Эрдэнэт хотод болсон Монгол Улсын төрийн захиргаа 100 дугаар өдөр сайн төгсгөл 1978 онд Эрдэнэт орон болон байгуулагдсан.

АЙМГИЙН ГАЗРЫН ЗУРАГ

Орон аймаг нь Монгол улсын төхөөрөмж өдөр сайн төгсгөл 1978 онд Эрдэнэт орон болон байгуулагдсан. Дэлхийн төсвийн орлого 1000 өдөр сайн төгсгөл 1978 онд Эрдэнэт орон болон байгуулагдсан.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ӨГСӨН
ҮҮРЭГ, ДААЛГАВАР, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2024.05.30

Орхон аймаг

Д/д	Чиглэлийн он, сар	Дэс дугаар	Товч утга	Хэрэгжилт
1	2024.01.08	6/208	Зөрчлийн тухай хууль түүний хэрэгжилтийн тухай	Хяналтын улсын байцаагч С.Оюунцэцэг төлөвлөгөө гарган сар бүр мэдээг Хяналт шалгалтын газарт хүргүүлэн хэвшсэн.
2	2024.01.09	5/218	Үл хөдлөх хөрөнгө	Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн тасгийн улсын бүртгэгч нарт танилцуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
3	2024.01.11	6/401	Тушаал, чиглэл хүргүүлэх тухай	Хяналтын улсын байцаагч С.Оюунцэцэг УБЕГ-ын даргын 2024.01.10-ны өдрийн А/12 дугаар тушаалын дагуу зөрчлийн хяналтыг өдөр бүр тавьж хэрэгжүүлэн ажиллалаа.
4	2024.01.15	2/514	Дипломат гадаад паспорт	Чиглэлийн дагуу судалгааг гарган Гадаад харилцаа хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Азжаргалд мэдэгдэж хүргүүлсэн болно.
5	2024.01.17	1/655	Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай /Сар бүр мэдээ авах тухай/	Хяналтын улсын байцаагч С.Оюунцэцэг чиглэлийн дагуу хяналт тавин сар бүрийн 25-ны дотор мэдээг Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

6	2024.01.17	6/641	Чиглэл хүргүүлэх тухай /Хялбаршуулсан журам, мэдээ авах тухай/	zurchliin.san@burtgel.gov.mn хаягт мэдээг сар бүр тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.
7	2024.01.25	3/1100	Чиглэл хүргүүлэх тухай /Төлбөрийн мэдээлэл/	Чиглэлийн дагуу Улсын ахлах бүртгэгч болон Улсын бүртгэгч нарт үүрэг өгч ажилласан.
8	2024.02.01	1/1461	Чиглэл хүргүүлэх тухай /Хөтлөх нэрийн жагсаалт/	Чиглэлийн дагуу Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж хөтлөх нэрийн жагсаалт үйлдэж хэрэгжүүлэн ажиллалаа.
10	2024.02.04	4/2151	Чиглэл хүргүүлэх тухай /Хуулийн этгээдийн бүртгэл засвар өөрчлөлт/	Хуулийн этгээдийн Улсын бүртгэгч М.Цогтбаатарт танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгон ажиллалаа.
11	2024.02.20	5/2170	Чиглэл хүргүүлэх тухай /Эд хөрөнгө/	Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт танилцуулан хэрэгжүүлж ажиллалаа.
12	2024.03.01	5/2717	Чиглэл хүргүүлэх тухай /Онлайн мэдүүлэг/	Чиглэлийг Хуулийн этгээд эд хөрөнгийн бүртгэгч нарт танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.
13	2024.03.04	2/2820	Чиглэл хүргүүлэх тухай /Захиалгын орон сууц/	Чиглэлийн дагуу Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн хариуг e.suvderdene@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.

14	2024.03.19	4/3519	Чиглэл хүргүүлэх тухай /Мөнгөн зээлийн тухай хууль/	Чиглэлийн дагуу Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Цогтбаатар нарт чиглэлийг хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосон.
15	2024.03.25	5/3784	Чиглэл хүргүүлэх тухай /Үл хөдлөх эд хөрөнгө/	Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэнд бүртгэгч нарт танилцуулан хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосны дагуу ажиллаж байна.
16	2024.04.11	2/4697	Чиглэл хүргүүлэх тухай /MNS7023:2023/ стандарт	Албан хаагч нарт танилцуулсан.
17	2024.04.12	5/4803	Чиглэл хүргүүлэх тухай /Эд хөрөнгийн бүртгэл/	Улсын ахлах бүртгэгч С.Жамбалсүрэнд бүртгэгч нарт танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллалаа.
18	2024.04.12	4/4802	Чиглэл өгөх тухай /Бие даах хичээл/	Хүний нөөцийн программ дахь Бие даах хичээлийг судлаагүй үлдсэн Улсын бүртгэгч Н.Алтанцэцэгт яаралтай судлах талаар үүрэг болгон өгсөн.
19	2024.04.26	3/5531	Чиглэл хүргүүлэх тухай /Шилжилт хөдөлгөөн зогсоох тухай/	УБЕГ-ын даргын 2024.04.25-ны өдрийн А/61 тушаал болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоосон. Мөн зогсоосон тухай тэмдэглэлийг үйлдэн хүргүүлсэн.

20	2024.04.29	6/5641	Чиглэл хүргүүлэх тухай /Шилжилт хөдөлгөөн зогсоох ИУБ22 маяг/	Чиглэлийн дагуу Хяналтын улсын байцаагч улсын бүртгэгч нараас ИУБ22 маягтыг хүлээн авч шалган, лацдаж хадгалав.
21	2024.05.01	7/5796	Чиглэл хүргүүлэх тухай /Шил ажиллагаа/	Чиглэл болон нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу shilen.gov.mn сайтад мэдээ мэдээллийг шалган байршуулсан.
22	2024.05.01	4/5784	Чиглэл хүргүүлэх тухай /E-business/	Чиглэлийн дагуу Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Цогтбаатарт Хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтыг хуулийн хугацаанд хурдан шуурхай шийдвэрлэн баталгаажуулахыг үүрэг болгосон.
23	2024.05.17	2-2/6730	Чиглэл хүргүүлэх тухай /ХХОАТ суутган авах тухай/	Чиглэлийн дагуу Монгол Улсын ЗГ-ын 83-р тогтоолоор олгогдож мөнгөн урамшууллалыг тооцохдоо ХХОАТ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцооллыг гаргаж хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосон.
Үүрэг даалгавар				
1	2024.04.25	6/4865	Үүрэг, даалгавар хүргүүлэх тухай	Чиглэлийн дагуу хяналт шалгалт хийж hyanalt@burtgel.gov.mn хаягт 2024.04.22, 2024.04.29, 2024.05.08-ны өдрийн дотор илгэх хуудсаар хариуг хүргүүлэн ажиллалаа.

2	2024.01.09	№01	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
3	2024.01.23	№02	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
4	2024.01.30	№03	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
5	2024.02.19	№04	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
6	2024.02.19	№05	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
7	2024.03.26	№06	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
8	2024.04.22	№07	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.

9	2024.05.13	№08	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.
10	2024.05.27	№09	Шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар	Хугацаа болоогүй.
11		№01	Даргын зөвлөлийн хурал	Хариуг хугацаанд хүргүүлэн ажиллалаа.
12		№02	Даргын зөвлөлийн хурал	Үүрэг даалгавар өгөгдөөгүй.
13	2024.04.25	№03	Даргын зөвлөлийн хурал	Үүрэг даалгаврын биелэлтийг гарган БТДШГ-т хугацаанд хүргүүлэн ажилласан.
	2024.05.02	№04	Даргын зөвлөлийн хурал	Тус хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн биелэлтийг хугацаанд ochirbat@burtgel.gov.mn хаягт хүргүүлэн ажиллалаа.

